

134



Б И М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

19 91 оны 10 сарын 12

№ 342

Улаанбаатар хот

Улсын үйлвэрийн газар
байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Ус сувгийн ашиглалтын газрыг БИМАУ-ын
Аж ахуйн нэгжийн тухай хуулийн цагуу Ус сувгийн ашиглалтын
газар /УҮГ/ болгон байгуулсугай.

2. Ус сувгийн ашиглалтын газар /УҮГ/-ын дүрмийг хавсрал-
тын ёсоор баталсугай.

3. Ус сувгийн ашиглалтын газар /н.Эрлэнэбаатар/-т үүрэг
болгох нь:

а/Ус сувгийн системийн байршил онцлогийг харгалзан
тайлан тэнцэлтэй аж ахуйн нэгж байгуулж, улсын бүртгэлд бүрт-
гүүлэх арга хэмжээ авах;

б/Ашиглалтгүй байгаа ЭО-4I2I маркийн эксковаторыг
өмч хувьчлалын комисст шилжүүлж дуудлагын хуцалцаанд оруулах.

4. Энэ тогтоол гарсантай холбогцуулан Улаанбаатар хотын
Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны "Дүрэм батлах тухай" 1991
оны 86 дугаар тогтоолын 22 дугаар хавсралт, "Улаанбаатар хотын
гүйцэтгэх захиргааны харъяа байгууллагуудын уширцлага, зохион
байгуулалт, цалингийн санг батлах тухай" 1991 оны 2 дугаар
тогтоолын I-ийн I7 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд
тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

[Handwritten signature]

[Handwritten signature]

Д.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
гүйцэтгэх захиргааны 1991 оны
2-дугаар тогтоолоор батлав.

**УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН
АШИГЛАЛТЫН ГАЗАР "УУГ"-ЫН
ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1. Улаанбаатар хотын Ус сувгийн ашиглалтын газар нь Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, үйлдвэр аж ахуй, үйлчилгээний бусад газрын унд ахуйн хэрэгцээний усаар тасралтгүй хангах, гарсан бохир усныг татан зайдуулж цэвэрлэх ажлын БНМАУ-ын төрийн өмчид тулгуурлан явуулах улсын үйлдвэрийн газар "УУГ" бөгөөд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж удирдана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2. Ус сувгийн ашиглалтын газар нь БНМАУ-ын хууль тогтоомж, Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүдэлгчид, гүйцэтгэх захиргааны шийшвэр, эрх зүйн акт, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаан Ус сувгийн ашиглалтын газрын даргыг тэрээний үндсэн дээр томилон ажиллуулна.

4. Газрын дарга нь ус сувгийн аж ахуйн үйл ажиллагааг удирдан Улаанбаатар хотын Ардын Хурал, гүйцэтгэх захиргааны өмнө ажлаа хариуцан тайлагнах бөгөөд эрх хэмжээ нийхээ асуудлаар БНМАУ-ын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал, заавар гаргаж байгууллагын хүрээнд мөрдүүлнэ.

5. Ус сувгийн ашиглалтын газрын даргын тушаалаар аж ахуйн нэгж байгуулж улсын бүртгэлд бүртгүүлнэ. Харьга нэгжийн дүрмийг баталж даргыг тэрээний үндсэн дээр томилно.

Байгууллагын эд хөрөнгийг БНМАУ-ын хууль тогтоомжинд, заасны дагуу захиран зарцуулна.

Байгууллага иргэнтэй тэрээ, хэлцэл хийж үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтооно.

6. Ус сувгийн ашиглалтын газар нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулан ажиллана.

7. Ус сувгийн ашиглалтын газар нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Ус сувгийн ашиглалтын газрыг байгуулах, бүртгэх

8. Ус сувгийн ашиглалтын газрыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр байгуулна.

9. Ус сувгийн ашиглалтын газар түүний аж ахуйн нэгжүүд нь татварын улсын албанд бүртгүүлнэ.

Дөрөв. Ус сувгийн ашиглалтын газрын эц хөрөнгө

10. Ус сувгийн ашиглалтын ^{газрын} эц хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Уг эц хөрөнгөө БНМАУ-ын хууль тогтоомж, болон дүрмэндээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин ашиглаж захиран зарцуулна.

11. Сэлбэр нэгжид оруулсан хувь хөрөнгөө өөрийн ланснаас хасахгүй бөгөөд энэ өмчийг Ус сувгийн ашиглалтын газар төрийн өмнө хариуцна.

12. Ус сувгийн ашиглалтын газрын дүрмийн сангийн хэмжээ /сая төгрөг байна.

Тав. Ус сувгийн ашиглалтын газрын үүрэг, эрх

13. Ус сувгийн ашиглалтын газар дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.
а/ Үйлдвэрлэлд шинжлэх ухаан техникийн ололт, тэргүүний арга, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх үүнтэй холбогдсон мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх арга хэмжээг төлөвлөн харгалзуулна.

б/ Ус сувгийн аж ахуйн үйл ажиллагаанд шаардагдох машин техник, тоног төхөөрөмж, сэлбэг харагсгал зэрэг үйлдвэрлэл-техникийн зориулалттай бүтээгдэхүүний нэгдсэн захиалгыг боловсруулан гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай худалдаа явуулж харьяа нэгжүүдэд хувиарлах

в/ Банкны зээлийн захиалга боловсруулах, хуваарь төлөвлөгөө хийх, зээдээр өгсөн болон төсвөөс олгож буй хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах ажлыг зохион байгуулна.

г/ Хамт олны нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэнэ.

д/ Аж ахуйн нэгжүүдийн үндсэн хөрөнгийн ашиглалт, материалын үнэт зүйл, мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж, баримтын шалгалт хийхийн хамт, хөрөнгө оруулалт, их засварын төлөвлөгөө боловсруулан баталж мөрдөнө.

3.

е/Барилга байгууламжийн өргөтгөл, их засварын зураг төсвийг хий, техник ашиглалтын норм, дүрэм аргачлал, зааврыг боловсруулж мөрдөнө.

ё/Үйлдвэрлэл үйлчилгээний улсын захиралга, хэрэглэгчидтэй байгуулсан аж ахуйн гэрээний үүрэг, элийн засгийн төлөвлөгөөт үзүүлэлтийг нэр төрөл, тоо чанараар биелүүлэн ашигт ажиллагааны түвшинг хангаж ажиллана.

ж/Үнд-ахуйн усны улсын стандартын шаардлага, бохир усны цэвэршилтийн үзүүлэлтийг хангаж, хэрэглэгчдийн усны зарцуулалт бохир усны чанарт тогтмол хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулна.

з/Аж ахуйн нэгжүүдийг мэргэжилийн удирдлагаар ханган хяналт тавих, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

и/Хөдөлмөрчдийн санал гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж байх, харъяа нэгжүүдэд шалгаж шаардлагатай арга хэмжээ авна.

к/Засгийн газраас тогтоосон, цэвэр, бохир усны хөлсний тарифыг мөрдөн ажиллана.

л/Банк, санхүү, статистикийн байгууллагад тэлгээрээс тогтоосон журмын дагуу мэдээ, тайлангаа үнэн зөв, тогтмол мэдээлж байна.

14. Ус сувгийн ашиглалтын газар дор дурдсан эрх эдлэнэ.

а/Аж ахуйн нэгжүүдийн ажлыг шалган зааварчлах, тэлгээрийн удирдах ажилтны илтгэл сонсголыг авч хэлэлцэх, үүрэг даалгавар өгч биелэлтийг нь тэргүүдэн авах.

б/Ажлын өндөр амдалт гаргасан тэргүүний хүмүүсийг шагнаж урамшуулна.

в/Ус сувгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээний асуудлаар семинар зөвлөлтөөн, үзүүлэх сургууль, болзолт уралдааныг байгууллагынхаа хэмжээнд зохион байгуулах.

г/Гадаад орны холбогдох байгууллагатай тогтоосон журмын дагуу харилцаа тогтоож хамтран ажиллана.

д/Аж ахуйн нэгжүүд нь хууль тогтоомжинд нийцээгүй буюу хөдөлмөрчид, нийгмийн эрх ашигт харшилсан тушаал шийдвэр гаргавал цуцлана.

Зургаа. Ус сувгийн ашиглалтын газрыг өөрчлөн байгуулах, татан буудгах

15. Ус сувгийн ашиглалтын газрыг өөрчлөн байгуулах, татан буудгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.